

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Цагдаагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2023/10/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Эрдэнэт хот 2023 он	Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn Аудитын менежер: Б.Буян-Ундрах Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn Аудитор: Б.Азжаргал Утас: 70357955 Цахим хаяг: azjargalb@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна

Нэг. Дүгнэлт

	ОРХОН АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГА А.ЛХАГВАДОРЖ ТАНАА
ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР	
61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум, Урт булаг баг, Ханддоржийн гудамж, Утас/Факс: 70359826 Цахим шуудан: orkhon@audit.gov.mn	
2024.08.24 № 47	
танай _____-ны № _____-г	
Өөрчлөлтгүй дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Цагдаагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p>	
<p>Орхон аймгийн Цагдаагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p>	
Дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
Асуудлыг онцолсон хэсэг	
<p>Орхон аймгийн Цагдаагийн газар нь 2022 оны санхүүгийн тайлангийн хугацаанд Улсын төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилт 3,985,089.6 мянган төгрөг, өөрийн орлого 3,226,510.7 мянган төгрөг нийт 7,211,600.3 мянган төгрөгийг үндсэн дансанд, нэмэлт дансаар гэрээт хамгаалалтын орлого 1,644,800.0 мянган төгрөг /Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ/, орон нутгийн төсвөөс 247,800.0 мянган төгрөг, галт зэвсгийн сургалт болон бусад орлого 27,600.0 мянган төгрөг нийт 1,920,200.0 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна. Дээрх онцгойлсон асуудалтай холбоотой аудиторын дүгнэлт өөрчлөгдөөгүй болно.</p>	
Аудитын гол асуудал	
<p>АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй байна.</p>	
<small>D:\my doc \alban bichig\2023-A4.doc</small>	

Бусад асуудлын хэсэг

Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 452 дугаар тогтоолоор "Цагдаа, дотоодын цэргийн албан тушаалын цалингийн сүлжээ" шинэчлэн батлагдсантай холбоотой 12 сарын цалинд өөрчлөлт орсон байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй Төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	367,700,055.35	461,308,438.65
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,889,880,811.03	2,894,022,755.80
	Нийт хөрөнгийн дүн	3,257,580,866.38	3,355,331,194.45
	Нийт өр төлбөрийн дүн	3,257,580,866.38	3,355,331,194.45
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,257,580,866.38	3,355,331,194.45
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,257,580,866.38	3,355,331,194.45
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	8,569,871,639.62	9,623,025,406.75
	Үйл ажиллагааны зардлын дүн	9,121,179,180.58	9,525,275,078.68
	Үйл ажиллагааны үр дүн	-551,307,540.96	97,750,328.07
	Үйл ажиллагааны бус үр дүн	-551,307,540.96	97,750,328.07
	Үйл ажиллагааны нийт үр дүн	-551,307,540.96	97,750,328.07
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,073,917,930.22	1,072,751,191.22
	Тайлант оны үр дүн		97,750,328.07
	Эцсийн үлдэгдэл	3,808,888,407.34	3,355,331,194.45
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	8,404,334,230.00	9,408,224,179.00
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	8,404,334,230.00	9,335,850,755.00
	Үйл ажиллагааны ЦМГ	00.00	72,373,424.00
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	00.00	12,502,520.00
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	00.00	59,870,904.00
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	00.00	59,870,904.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	59,870,904.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	59,870,904.00
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	7,211,600,300.00	7,349,524,896.50
	Урсгал зардал	7,211,600,300.00	7,349,524,896.50
	Хөрөнгийн зардал	7,172,282,200.00	7,153,523,481.98
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	7,211,600,300.00	7,349,524,896.50
	Улсын төсвөөс санхүүжих	3,985,089,600.00	3,922,620,481.50
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,226,510,700.00	3,426,904,415.00

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 17,655.9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 480.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 17,175.9 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж хүргүүлсэн.

3.1 Төлбөрийн акт: Тогтоогоогүй

3.2 Албан шаардлага:

Илрүүлэлт: Албан томилолтын зардлаас албан хаагчдын уралдаан тэмцээнд оролцуулах зардал 480.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

3.3 Зөвлөмж

Илрүүлэлт: Албан томилолтын хуудас баталгаажуулаагүй анхан шатны баримт хангалтгүй олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Зөвлөмж: Анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх.

Илрүүлэлт: Батлагдсан төсвийг зардлын бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаал "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 3.1.6 дахь заалт "Төсвийн тухай хуулийн 42.4-т заасны дагуу дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Зөвлөмж: Бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах.

Илрүүлэлт: Согтолт хэмжигч Алкотест-5000 маркийн багаж, тоног төхөөрөмж нийлүүлэх худалдан авах ажиллагаа хуулийн дагуу хийгдээгүй байна.

Энэ нь "Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ", 14.4-д "цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", 14.5-д "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана", ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8.1.1-д "харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар" гэж заасантай нийцэхгүй байна.

Зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орхон аймгийн Цагдаагийн газар	4	17,655.9			1	480.0	3	17,175.9				
Дүн	4	17,655.9			1	480.0	3	17,175.9				

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	Орхон аймгийн Цагдаагийн газар	1	1			1			
НИЙТ		1	1			1			